



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 153

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.1, 5.2.7 дугаар заалтыг үндэслэн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт хийгдэх 150 суудалтай Хүүхдийн цэцэрлэгийн барилга, 240 хүний суудалтай Соёлын төвийн барилга, Төрийн албан хаагчдын барилгын их засвар, Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг, Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт, Усан хангамж ариутгал татуургын шугам сүлжээ, барилга байгууламж, Ахмад, хүндэтгэлийн өргөө, Хуучин эмнэлгийн барилга буулгалтын ажлуудын явцад хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: С.Нарантунгалаг (ЗДТГ-ын дарга)

Гишүүд: О.Улаанхүү (Улсын бүртгэгч)

Н.Загдхорол (ИТХ-ын нарийн бичгийн дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Ш.Отгонцэцэг (Соёлын төвийн эрхлэгч)

Х.Эрдэнэтуяа (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Д.Ганчимэг (Татварын улсын байцаагч)

Ж.Наранцэцэг (Ахмадын хорооны дарга)

А.Адъяа (Ган-Илч Дэлгэрцогт дахь салбарын дарга)

Ба.Баярмаа (ЗДТГ-ын нярав)

2.Гэрээний хугацаанд зураг төсвийн дагуу чанартай, өнгө үзэмжтэй хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.



ДАРГА

М.БАЯРСҮХ